210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	504,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	210,100.00	158,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181,400.00	163,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	98,600.00	-

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,658,700.00	5,150,000.00
210807	Газрын төлбөр	1,556,400.00	827,681.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,579,700.00	32,497,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,103,800.00	26,300,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,475,900.00	6,197,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,445,000.00	18,445,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,445,000.00	18,445,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,520,000.00	14,520,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,925,000.00	3,925,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	386,365,300.00	278,304,000.00
223001	Бусад хөрөнгө	386,365,300.00	278,304,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,000,000.00	50,000,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,883,229,800.00	1,873,913,325.56
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	247,400,300.00	240,400,300.00
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	247,400,300.00	240,400,300.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,543,859,500.00	1,520,582,467.53
320001	Орон нутгийн төсвөөс	1,543,859,500.00	1,520,582,467.53
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	91,970,000.00	112,930,558.03
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	91,970,000.00	112,930,558.03
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(88,759,300.00)	66,144,575.92
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(88,759,300.00)	(66,144,575.92)
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(88,759,300.00)	(66,144,575.92)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	92,292,818.10
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	158,437,394.02

2.6. Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	27,683,619.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,683,619.00
122	Тусламжийн орлого	27,683,619.00
1221	Хандив тусламж /дотоод/	27,683,619.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,683,619.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,683,619.00

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,155,619.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,155,619.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,155,619.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,500.00
210104	Урамшуулал	514,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,168.00
210201	Тэтгэврийн даатгал	43,733.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,116.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,029.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,290.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	806,000.00
210301	Гэрэл, цахилгаан	806,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,618,112.00
210402	Тээвэр, шатахуун	3,145,782.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,472,330.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,887,839.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,740,000.00
210602	Тавилга	10,000,000.00
210604	Урсгал засвар	3,147,839.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,420,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,420,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,850,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,850,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,528,000.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,528,000.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,528,000.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь байгууллагын манлайллыг дээшлүүлэх, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг түргэн шуурхай зохион байгуулах, төрийн албан хаагчдын ёс зүйг чанд сахиж иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Тайланг хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10.9 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	92.3	158.4	66.1
Авлага	232.9	229.2	(3.7)
Бараа материал	211.4	233.8	22.4
Үндсэн хөрөнгө	5,744.9	5,649.3	(95.6)
Нийт хөрөнгө	6,281.6	6,270.7	(10.9)
Өр төлбөр	-	138.3	138.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,281.6	6,132.4	(149.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,281.6	6,270.7	(10.9)

Эх сурвалж: Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 158.4 сая төгрөг болж, өмнөх оноос 66.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	92.3	158.4	66.1
Төгрөг	92.3	158.4	66.1
Төрийн сангийн харилцах	92.3	158.4	66.1
Дүн	92.3	158.4	66.1

Эх сурвалж: Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 158.4 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 32.7 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 95.1 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 30.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 229.2 сая төгрөг болж, өмнөх оноос 3.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон авлага	2.3	0.4	-1.9
Зээлийн авлага	209.2	209.0	-0.2
Зээлийн хүүгийн авлага	14.3	11.8	-2.5
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	-	0.9	0.9
Байгууллагаас авах авлага	-	-	-
Хувь хүмүүсээс авах авлага	7.1	7.1	-

Дүн	232.9	229.2	-3.7
------------	--------------	--------------	-------------

Эх сурвалж: Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Авлагын дансны эхний үлдэгдэл 232.9 сая төгрөг байснаас тайлант онд эцсийн үлдэгдэл 229.2 сая төгрөг болж 3.7 сая төгрөгөөр буурсан байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 233.7 сая төгрөг болж, өмнөх оноос 22.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	0.0	58.0	58.0
Аж ахуйн материал	183.1	147.4	-35.7
Бусад хангамжийн материал	10.6	10.6	0.0
Мал амьтад	17.7	17.7	0.0
Дүн	211.4	233.7	22.3

Эх сурвалж: Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бараа материалын үлдэгдэл өссөн нь Засаг даргын тамгын газарт орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгө данс бүртгэлд тусгасан нь бараа материал өсөхөд голлон нөлөөлсөн байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 5,649.3 сая төгрөг болж, өмнөх оноос 95.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	5,505.9	5,580.2	74.3
Хуримтлагдсан элэгдэл	-743.6	-879.1	-135.5
Авто тээврийн хэрэгсэл	386.7	371.4	-15.3
Хуримтлагдсан элэгдэл	-145.0	-162.6	-17.6
Машин тоног төхөөрөмж (компьютер)	322.6	317.6	-5.0
Хуримтлагдсан элэгдэл	-257.0	-275.1	-18.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	89.7	99.7	10.0
Хуримтлагдсан элэгдэл	-39.7	-59.8	-20.1
Зам гүрийн байгууламж	263.9	263.9	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-154.5	-166.9	-12.4
Бусад үндсэн хөрөнгө	344.9	394.1	49.2
Хуримтлагдсан элэгдэл	-245.0	-252.0	-7.0
Ном	5.8	5.8	0.0
Программ хангамж	2.3	7.3	5.0
Хуримтлагдсан элэгдэл	-2.3	-3.1	-0.8
Бусад биет бус хөрөнгө	410.2	407.9	-2.3
Дүн	5,744.9	5,649.3	-95.6

Эх сурвалж: Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,649.3 сая төгрөг болж 95.6 сая төгрөгөөр буурсан нь авто тээврийн хэрэгсэл 15.2 сая төгрөг, машин тоног төхөөрөмжийн 5.1 сая төгрөг, тавилга эд хогшил 10.0 сая төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл тайлант онд 138.3 сая төгрөг болж өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажилтнуудтай холбоотой өглөг			
Бараа үйлчилгээний зардлын өглөг			
Байгууллагад төлөх өглөг	0.0	138.3	138.3
Хувь хүмүүст төлөх өглөг			
Дүн	0.0	138.3	138.3

Эх сурвалж: Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 138.3 сая төгрөг болж өссөн нь Орон нутгийн хөгжлийн сан 56.3 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургууль 44.6 сая төгрөг, Цэцэрлэг 7.6 сая төгрөг, Соёлын төв 11.3 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 18.5 сая төгрөгөөр тус тус өр төлбөр нэмж үүссэнээс шалтгаалсан байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 6,132.4 сая төгрөг болж, өмнөх оноос 149.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	583.9	311.2	-272.7
Өмч /төрийн/	-	272.7	272.7
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	5,416.3	5,276.5	-139.8
Өмнөх үеийн үр дүн	5,275.8	5,425.6	149.8
Тайлант үеийн үр дүн	140.5	-149.1	-289.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	281.4	272.0	-9.4
Дүн	6,281.6	6,132.4	-149.2

Эх сурвалж: Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 6,132.4 сая төгрөг болж 149.2 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүн 139.8 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс 9.4 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Хяргас сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн сумын төсөв тодотгон батлах тухай 19 дүгээр тогтоолоор Хяргас сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 641.7 сая төгрөгийн орлого сумын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 612.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 29.6 сая төгрөгөөр буюу 4.6 хувиар дутуу биелүүлсэн байна.

3.5.8 Зардлын данс

Нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын данстай холбоотой 1,591.9 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Хяргас сумын Засаг даргын тамгын газар:

- Тамгын газрын бараа материалын тайлангийн мал амьтад дансанд бүртгэлтэй Герефорд үйлдвэрийн 7,9 сая төгрөгийн 2 бухыг нас дэвшилт хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 5.1.5 дэх заалтад “Хэмжигдэхүйц байх”, 14.4.7 дахь заалтад Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс”, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул нас дэвшилт хийж залруулга хийлгэсэн.
- Хяргас сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 61.9 сая төгрөгийн 6 зарлагын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 419.9 сая төгрөгийн 6 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 53.6 сая төгрөгийн 41 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 651.7 сая төгрөгийн 8 орлогын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27.4 сая төгрөгийн 4 зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 14.1 сая төгрөгийн 5 шийдвэрийн мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлангийн 351.3 сая төгрөгийн 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.

Хяргас сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

- Хяргас сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тайлант оны 8 дугаар сард нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг бодоходоо иргэдийн Төлөөлөгчийн Хурлын нарийн бичгийн даргын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг 1.0 сая төгрөгөөр илүү тайлагнаж 0.2 сая төгрөгийн шимтгэлийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул авлагаар бүртгүүлэн залруулга хийлгэсэн.
- Хяргас сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/08 дугаар тушаалаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг Улаанбаатар хотод сургалтад суух, туршлага судлах ажлаар явахад ирж, очих унааны зардал гэж 4.0 сая төгрөгийг аж ахуйн нэгжийн дансаар дамжуулан төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага өгсөн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,249.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,249.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,972.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,535.6 сая төгрөгийг урсгал зардалд, 386.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 50.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн 2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор нийт зардлыг 277.7 сая төгрөгөөр бууруулан төсөвт тодотгол хийсэн байна.

Нийт зардлын 247.4 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,543.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 92.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 240.4 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,520.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 112.9 сая төгрөгийг үндсэн ажиллагааны орлогоос нийт 1,873.9 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,807.8 сая төгрөг буюу 91.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 25.7 сая төгрөг, нийт 27.7 сая төгрөгийн орлого хүлээн авч зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.6.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хяргас сумын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2025 онд харьцуулалтын аргаар 9, шууд худалдан авалт 13, нийт 22 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Тайлант онд огт хэрэгжээгүй 2 төсөл арга хэмжээ, дутуу хэрэгжсэн 5 төсөл арга хэмжээ, төрийн сангийн зарлагын гүйлгээг хязгаарласантай холбоотой санхүүжилт дутуу олгосон 2 төсөл арга хэмжээ байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/59 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,075.3 сая төгрөгийн 1.0 хувиар буюу 20.8 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 16.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,484.0 сая төгрөгийн 1 хувиар буюу 34.8 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 27.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Хяргас сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 184 мэдээллээс хугацаандаа оруулсан 181, хугацаа хоцроосон 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хяргас сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн. Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хяргас сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах асуудлыг анхаарч үзэхээр байна. Үүнд:

Хяргас сумын Засаг даргын тамгын газар:

Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан Хяргас сумын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоонд байхгүй багийн сахиул, олон нийтийн байцаагч ажиллуулсан асуудлыг дараачийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Хяргас сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн 2 төсвийн байгууллага, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайланг нэгтгэгдсэн.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа орон нутгийн 1 төсвийн байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгч, 1 төсвийн байгууллага, 2 санг түүвэрт хамруулсан байна.

Нэгтгэлд хамрагдсан харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 1,591.9 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 8.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 1,583.8 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлого авах	1	4.0					1	4.0				
Дүн	1	4.0					1	4.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Дүн											
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
Дүн											
Нийт дүн											

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.БАТСҮХ/

2026 оны 03 дугаар сарын 24-ний өдөр